# Статистикийн хэлтэс

2016-09-13

Арвайхээр

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ХҮН АМ







**Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 08-р сард 1803 хүүхэд мэндэлж, 464 хүн нас барсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс төрсөн хүүхэд 53 буюу 2.8 хувиар буурч, нас барсан хүн 36 буюу 8.4 хувиар өссөн байна. Хүн амын ердийн цэвэр өсөлт өмнөх оны мөн үеийнхээс 89 хүнээр буюу 6.2 хувиар, 2014 оны мөн үеийнхээс 159 хүнээр буюу 10.6 хувиар буурчээ.**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ХӨДӨЛМӨР

### Шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд болон ажилд зуучлагдан орсон хүний тоо




Эхний 8 сарын байдлаар ажилгүй 25 иргэн шинээр бүртгүүлсэн байна.Шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд өмнөх оны мөн үеийнхээс 525 хүнээр буурчээ.

### Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо




Эхний 8 сарын байдлаар хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд 1585 байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 360 хүнээр буюу 18.5 хувиар, 2014 оны мөн үеийнхээс 657 хүнээр буюу 29.3 хувиар тус тус буурсан байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- ХӨДӨЛМӨР







Аймгийн хэмжээнд эхний 8 сарын байдлаар 1056 ажлын байр шинээр бий болж, өмнөх оны мөн үеийнхээс 227 буюу 27.3 хувиар өссөн байна.

Ажлын байрны 24.7 хувь нь ХАА-н салбарт, 22.0 хувь нь боловсруулах үйлдвэрт, 6.2 хувь нь барилгын салбарт, 2.0 хувь нь боловсролын салбарт, 11.2 хувь нь худалдааны салбарт, 0.5 хувь нь мэдээлэл холбооны салбарт, 33.4 хувь нь бусад салбарт бий болсон байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- НИЙГМИЙН ДААТГАЛ , ХАЛАМЖ







**2016 оны эхний 8 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 37.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 5.4 тэрбум төгрөгөөр буюу 16.9 хувиар өссөн байна.**

**Нийгмийн даатгалын сангийн зарлага эхний 8 сарын байдлаар 37.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 5.9 тэрбум төгрөгөөр буюу 18.8 хувиар өссөн байна.**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ- НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

**Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо**




**Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ, сая төг**




**Эхний 8 сарын байдлаар 32087 хүнд 6579.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт олгожээ. Өмнөх оны мөн үеийнхээс тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт авагчдын тоо 1672 хүнээр буюу 5.5 хувиар өсч, олгосон тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлтийн хэмжээ 605.8 сая.төг буюу 8.4 хувиар буурсан байна.**

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

**Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 8 сард 1799 эх амаржиж, 1803 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 49 эхээр, төрсөн хүүхдийн хувьд 53 хүүхдээр буюу 2.8 хувиар буурсан байна. Нялхсын эндэгдлийн 71.4 хувь нь 1 хүртэл насандаа, 28.6 хувь нь 1-5 хүртэл насандаа эндсэн байна. Өмнөх оны мөн үеэс 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд 17 хүүхдээр, 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд 6 хүүхдээр тус тус өсчээ.**

| | 2014 он | 2015 он | 2016 он | 2016/2015 % |
|---|---|---|---|---|
| Амаржсан эхийн тоо | 1877 | 1848 | 1799 | 97.3 |
| Амьд төрсөн хүүхэд | 1890 | 1856 | 1803 | 97.1 |
| Эхийн эндэгдэл | - | - | 2 | 2 дах |
| 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 21 | 23 | 40 | 173.9 |
| 1-5 хүртэл насандаа эндсэн хүүхэд | 6 | 10 | 16 | 160.0 |

# ХҮН АМ,НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд

## Халдварт өвчний гаралт




Халдварт өвчнөөр эхний 08 сард 1903 хүн өвчилж өмнөх оны мөн үеийнхээс 1231 хүнээр буюу 2.8 дахин өссөн байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 73.7 хувийг улаан бурхан, 9.7 хувийг салхинцэцэг, 5.9 хувийг тэмбүү, 2.7 хувийг сүрьеэ, 2.3 хувийг заг хүйтэн, 0.6 хувийг вируст гепатит, 1.2 хувийг трихомониаз, бусад 2.9 хувийг өвчнөөр өвчлөгсөд тус тус эзэлж байна.

# ХҮН АМ,НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Гэмт хэрэг




Аймгийн хэмжээнд эхний 08 сард 345 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 19 гэмт хэргээр буюу 5.2 хувиар буурсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 60.3 хувь нь сумдад, 39.7 хувь нь аймгийн төвд бүртгэгджээ.

Хулгайн гэмт хэргийн 70.7 хувийг иргэдийн орон байрны хулгай, 16.3 хувийг малын хулгай тус тус эзэлж байна. Гэмт хэрэгт холбогдсон 328 сэжигтэн яллагдагчийн 171 хүн буюу 52.1 хувь нь 18-35 хүртэлх насныхан, 113 хүн буюу 34.4 хувь нь 35-аас дээш насныхан, 44 хүн буюу 13.4 хувь нь 17 хүртэлх насныхан байна. Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын 13.4 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 39.0 хувь нь ажилчин, малчин, 45.4 хувь нь ажилгүй иргэд байна. Автомашин жолоодох эрхээ хасуулсан жолооч 200 болж, өмнөх оны мөн үеийнхээс 109 хүнээр буюу 35.2 хувиар буурсан байна. Гэмт хэргийн улмаас 160 хүн бэртэж, 23 хүн нас барсан байна.

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

## Мал төллөлтийн хувь




## Төл бойжилтын хувь



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

## Хорогдсон том малын оны эхний малд эзлэх хувь




### Өвчнөөр хорогдсон малын нийт хорогдолд эзлэх хувь




### Хээлтэгчийн хорогдлын нийт хорогдолд эзлэх хувь



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

## Том малын зүй бусын хорогдол, эхний 8 сард



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

## Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ



# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

## Тариалсан талбай, төмс, хүнсний ногоо



# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – АЖ ҮЙЛДВЭР

## АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд оны үнээр эхний 8 сард 13.7 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 13.3 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2.5 хувиар, борлуулалтын орлого 4.4 хувиар тус тус өссөн байна

**Нийт борлуулалтын дунд салбаруудын эзлэх хувь**



# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өнгөрсөн онтой харьцуулахад уул уурхайн олборлох салбарын үйлдвэрлэлт 33.4 хувиар,боловсруулах салбарын үйлдвэрлэлт 1.3 хувиар тус тус өсч, харин дулаан үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 2.6 хувиар буурсан байна.

**Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт оны үнээр, сая төгрөг**



# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – ТЭЭВЭР

**Авто замын тээврээр зорчигчдын тоо, тээсэн ачаа 2016 оны 8 сарын байдлаар**




Автозамын тээврээр эхний сард давхардсан тоогоор 162.8 мянган зорчигч зорчиж, 21.9 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс зорчигчдын тоо 11.9 мян.хүн буюу 7.9 хувь, тээсэн ачаа 1.5 мян.тн буюу 7.4 хувиар өсчээ.

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – ХОЛБОО

**ХОЛБООНЫ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, мян. төг**

| Үзүүлэлт | 2015 VIII | 2016 VIII | 2016. VIII /2015. VIII |
|---|---|---|---|
| Нийт орлого | 397095.3 | 442662.2 | 111.5 |
| Үүнээс:Хүн амаас орсон орлого | 151907.9 | 149720.4 | 98.6 |
| Телефон цэгийн тоо | 970 | 850 | 87.6 |
| Ажиллагсадын тоо | 86 | 94 | 109.3 |

Суурин утасны цэгийн тоо



# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

WWW.1212.mn

uvurkhangai@nso.mn
uvurkhangai.nso.mn